



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/320

Булган сум

Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд оролцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.6, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээ, гэрээний 1.7 дахь заалт, Батлан хамгаалах сайдын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/50 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.БНМАУ-ын гарамгай баатар, хурандаа Лодонгийн Дандарын мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг Бүрэгхангай суманд зохион байгуулсугай.

2.Тэмцээнд шаардагдах 3,701,600 (Гурван сая долоон зуун нэг мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй


3.Дөл цогцолбор тэмцээнд оролцох баг тамирчдын аюулгүй ажиллагааг ханган ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Ч.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 13-ны/ний өдрийн А.320 дугаар
захирамжийн хавсралт



ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ЗАРДАЛ

Д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	2	3	4
1	Унаа, зардал	201.600	авто машин-1 *80 л *2520 =201600 төг
2	Шүүгчдийн хоол	350.000	7 хүн *25000* 1 өдөрт 2 удаа =350.000 төг
3	Шүүгчдийн зардал	350.000	7 шүүгч *50000*=350000
4	Шагналын зардал	2.800.000	1 дүгээр байр 1000000 2 дугаар байр 800000 3 дугаар байр 600000 Тусгай байр-2*200000=400000
Нийт дүн			3,701,600